НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу-1, Хөвсгөл лэйк сити товер-8/1, 3-р давхар
Утас/Факс: (976-11) 32-02-48
http://www.umch.ub.gov.mn

2019·02·26. № 2/204

танай ____________-ны №____________-т

“АХМАДЫН ХОТХОН-1” ОНӨААТҮГ-Т

Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 2019 оны А/123 дугаар захирамжийн дагуу 3,497,390,000.0 /гурван тэрбум дөрвөн зуун ерэн долоон сая гурван зуун ерэн мянган/ төгрөгийн үнэ бүхий “Түрээсийн 70 айлын орон сууцны”-ны барилга байгууламжийг данс бүртгэлдээ бүртгэн авч захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хөрөнгө бүртгэсэн тухай тушаалын хуулбарыг 14 хоногийн дотор манай газарт ирүүлэхийг мэдэгдье.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/123 дугаар захирамжийн хуулбарыг хавсаргав.

ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ,
МЕНЕЖМЕНТ, ХУВЬЧЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЭНХБОЛД

ТТА-2371

11505000243

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 25 өдөр Дугаар А/123 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид хөрөнгө
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Хөрөнгө бүртгэн авах тухай" 2019 оны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо, 21 дүгээр хорооллын нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 3,497,390,000.0 /гурван тэрбум дөрвөн зуун ерэн долоон сая гурван зуун ерэн мянган/ төгрөгийн өртөг бүхий "Түрээсийн 70 айлын орон сууц"-ны барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2."Түрээсийн 70 айлын орон сууц"-ны барилга байгууламжийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг "Ахмадын хотхон-1" ОНӨААТҮГ /Ц.Отгонбат/-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ,
АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ Ж.БАТБАЯСГАЛАН